



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 07 дугаар сарын 08
№ 26 /935/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1617

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1620

Монгол Улсын Их Хурлын
гишүүдийн бүрэн эрхийг хүлээн
зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын
даргыг сонгох тухай



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 523. | Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай | Дугаар 01 | 1617 |
| 524. | Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай | Дугаар 02 | 1620 |
| 525. | Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай | Дугаар 03 | 1621 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 526. | Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 76 | 1621 |
| 527. | Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 80 | 1622 |
| 528. | Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 81 | 1622 |
| 529. | Анхдугаар чуулганыг товлон зарлах тухай | Дугаар 87 | 1623 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|------|
| 530. | Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай | Дугаар 185 | 1623 |
| 531. | Журам батлах тухай | Дугаар 193 | 1626 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2016 оны 06 дугаар сарын 29-ний өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон доор дурдсан нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй:

- 1/Намсрайн Амарзаяа
- 2/Төмөрбаатарын Аюурсайхан
- 3/Октябрийн Баасанхүү
- 4/Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
- 5/Хавдисламын Баделхан
- 6/Сүхбаатарын Батболд
- 7/Жалбасүрэнгийн Батзандан
- 8/Батжаргалын Батзориг
- 9/Отгоогийн Батнасан
- 10/Баагаагийн Баттөмөр
- 11/Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
- 12/Жадамбын Бат-Эрдэнэ
- 13/Магваны Билэгт
- 14/Лувсанвандангийн Болд
- 15/Хаянгаагийн Болорчулуун
- 16/Сандагийн Бямбацогт
- 17/Жамбалын Ганбаатар
- 18/Даваагийн Ганболд
- 19/Дорждугарын Гантулга
- 20/Цэдэнгийн Гарамжав
- 21/Цэрэнпилийн Даваасүрэн
- 22/Дорждамбын Дамба-Очир
- 23/Борхүүгийн Дэлгэрсайхан
- 24/Болдын Жавхлан
- 25/Самандын Жавхлан
- 26/Гомбожавын Занданшатар
- 27/Данзангийн Лүндээжанцан
- 28/Лхагвын Мөнхбаатар
- 29/Жамъянгийн Мөнхбат
- 30/Цэндийн Мөнх-Оргил



- 31/Гомпилдоогийн Мөнхцэцэг
- 32/Дакейн Мурат
- 33/Загдхүүгийн Нарантуяа
- 34/Батсүхийн Наранхүү
- 35/Нямтайширын Номтойбаяр
- 36/Хишгээгийн Нямбаатар
- 37/Цэндийн Нямдорж
- 38/Наваан-Юндэнгийн Оюундарь
- 39/Дуламсүрэнгийн Оюунхорол
- 40/Мөнхөөгийн Оюунчимэг
- 41/Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
- 42/Бөхчулууны Пүрэвдорж
- 43/Шатарбалын Раднаасэд
- 44/Ядамсүрэнгийн Санжмятав
- 45/Даваажанцангийн Сарангэрэл
- 46/Батсүхийн Саранчимэг
- 47/Янгугийн Содбаатар
- 48/Отгонбилэгийн Содбилэг
- 49/Гомбожайн Солтан
- 50/Долгорсүрэнгийн Сумъяабазар
- 51/Агваансамдангийн Сүхбат
- 52/Дуламдоржийн Тогтохсүрэн
- 53/Ганзоригийн Тэмүүлэн
- 54/Дэндэвийн Тэрбишдагва
- 55/Чүлтэмийн Улаан
- 56/Батбаярын Ундармаа
- 57/Агваанлуvsангийн Ундраа
- 58/Ням-Осорын Учрал
- 59/Дамдины Хаянхярваа
- 60/Чимэдийн Хүрэлбаатар
- 61/Цэдэнбалын Цогзолмаа
- 62/Дамдины Цогтбаатар



- 63/Намсрайн Цэрэнбат
- 64/Содномын Чинзориг
- 65/Баттогтохын Чойжилсүрэн
- 66/Лхагваагийн Элдэв-Очир
- 67/Бямбасүрэнгийн Энх-Амгалан
- 68/Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
- 69/Жадамбын Энхбаяр
- 70/Лувсангийн Энхболд
- 71/Миеэгомбын Энхболд
- 72/Нямаагийн Энхболд
- 73/Өлзийсайханы Энхтүвшин
- 74/Содномзундуйн Эрдэнэ
- 75/Дондогдоржийн Эрдэнэбат
- 76/Жаргалтулгын Эрдэнэбат

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Миеэгомбын Энхболдыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ч.УЛААН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Монгол Ардын Намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Нямдорж, Ардчилсан Намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Ядамсүрэнгийн Санжмятав нарыг тус тус сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн тул Цэвэгмидийн Сумъяаг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 06 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нарангэрэлийн Энхмааг Өвөрхангай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн, Ганзоригтын Билгүүнийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Дагаагийн Байгалмааг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Ганбатын Мөнхтулга, Доржготовын Чанцалням нарыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Оюунчимэгийн Одгэрэлийг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дамдинсүрэнгийн Зоригтбаатарыг Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Жамбалын Мөнхтуяаг Төв аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Төмөрхүүгийн Батжаргалыг Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Төртогтохын Энхмандахыг Говьсүмбэр аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 06 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Дамдинсүрэнгийн Зоригтбаатарыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Ганзоригтын Билгүүнийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дагаагийн



Байгалмааг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Доржготовын Чанцалнямыг Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Жамбалын Мөнхтуяаг Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Төмөрхүүгийн Батжаргалыг Хөвсгөл аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 07 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 87

Улаанбаатар
хот

Анхдугаар чуулганыг товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Их Хурлын долоо дахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулганыг 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 11.00 цагт товлон зарласугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар
хот

Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний



04, 07, 21, 39, 44, 49, 51, 56, 61, 63, 64, 68, 69, 94 дүгээр бүлэгт заасан зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Энэ тогтоолыг 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД

Д.ЭРДЭНЭБАТ

Засгийн газрын 2016 оны 185 дугаар
тогтоолын хавсралт

**ИМПОРТЫН ЗАРИМ БАРААНЫ ГААЛИЙН АЛБАН
ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

Бүлэг	Зүйл	Үндэсний код	Барааны бичиглэл	Одоо мөрдөж буй албан татвар	Албан татварыг нэмэгдүүлэх хувь, хэмжээ
04	04.01		Саахар болон бусад амтлагчийн хольцгүй, шингэн сүү, цөцгий	5%	15%
	04.03		Саахар, эсхүл бусад чихэрлэг амтлагч, үнэр оруулагч, жимс, самар, эсхүл какаогийн хольцтой, эсхүл хольцгүй, өтгөрүүлсэн, эсхүл өтгөрүүлээгүй зөөхий, йогурт, тараг, хоормог, ферментжүүлсэн, эсхүл исгэсэн бусад сүү болон цөцгий	5%	15%
	04.04	0404.10.00	- Саахар, эсхүл бусад чихэрлэг амтлагчийн хольцтой, эсхүл хольцгүй, өтгөрүүлсэн, эсхүл өтгөрүүлээгүй шар сүү, хувиргасан шар сүү	5%	20%
	04.05		Цөцгийн тос, сүүнээс гаргаж авсан бусад өөх тос; өтгөн цөцгий	5%	15%
	04.06		Бяслаг ба аарц	5%	15%
07	07.01		Шинэ, эсхүл хөргөсөн төмс	15%	20%
	07.02		Шинэ, эсхүл хөргөсөн улаан лооль	5%	20%
	07.03	0703.90.00	- Ногоон сонгино болон сонгины төрлийн бусад ногоо	5%	15%
	07.04	0704.90.10	--- Бөөрөнхий байцаа	15%	20%
	07.06	0706.10.10	--- Шар лууван	15%	20%
		0706.10.20	--- Шар манжин	15%	20%
	07.07	0707.00.00	Шинэ, эсхүл хөргөсөн урт өргөст хэмх болон давжаа хэмх	5%	20%
07.10	0710.10.00	- Төмс	5%	20%	



21	21.05	2105.00.00	Какао агуулсан, эсхүл агуулаагүй зайрмаг, хүнсний зориулалтын бусад мөсөн бүтээгдэхүүн	5%	15%
39	39.25		Барилгын зориулалттай, бусад газар заагдаагүй хуванцар зүйлс		
		3925.20.10	--- Хаалга	5%	6.5%
		3925.20.20	--- Цонх	5%	6.5%
44	44.12	4412.94.00	-- Блокон хавтан, давхарлаж наасан хавтан, савхалсан хавтан	5%	10%
			- Хаалга, хаалганы хүрээ мод, босго:		
		4418.20.10	--- Хаалга	5%	20%
		4418.20.20	--- Хаалганы хүрээ, босго	5%	20%
49	49.10	4910.00.00	Бүх төрлийн хэвлэмэл хуанли (тасалбар хуанли орно).	5%	20%
	49.11	4911.10.00	- Худалдааны зар сурталчилгааны материал болон барааны каталог, түүнтэй төстэй бусад материал	5%	20%
51	51.06		Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины сэмлэсэн ноосон ээрмэл	5%	10%
	51.07		Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины самнасан ноосон ээрмэл	5%	10%
	51.08		Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, мал, амьтны нарийн үс, ноосон сэмлэсэн, эсхүл самнасан ээрмэл	5%	10%
56	56.02	5602.10.00	- Шивсэн эсгий, мяндсыг нь өөр хооронд нь хэрсэн бүтээгдэхүүн	5%	10%
		5602.21.00	-- Хонины ноос, эсхүл мал, амьтны нарийн үс, ноосон	5%	20%
61	61.14	6114.90	Нэхмэлийн бусад материалан	5%	20%
63	63.05	6305.32.00	-- Дамжлагын бөөний савлагааны зориулалттай, их даацын уян шуудай	5%	20%
64	64.03	6403.40.00	- Хамар нь металл хамгаалалттай бусад гутал	5%	20%



68	68.06	6806.10.10	--- Эрдэс чулуун хөвөн	5%	15%
		6806.10.60	--- Шаарган хөвөн	5%	15%
	68.10	6810.11.10	--- Барилгын блок (хөнгөн бетон гулдмай орно)	5%	15%
		6810.11.20	---- Силикат тоосго	5%	10%
		6810.19.10	-- Зам талбайн бетонон хашлага	5%	20%
		6810.19.20	-- Зам талбайн бетонон хавтан	5%	15%
		6810.91.30	--- Барилгын ханын төмөр-бетон бүтээц, хийц хэсэглэл	5%	20%
		6810.91.40	--- Барилгын тааз, дээврийн төмөр-бетон бүтээц, хийц хэсэглэл	5%	20%
		6810.91.50	--- Инженерийн байгууламжийн төмөр-бетон бүтээц, хийц хэсэглэл	5%	20%
		6810.91.60	--- Төмөр-бетон шат, гишгүүр	5%	20%
		6810.91.70	--- Төмөр замын бетонон дэр	5%	20%
		6810.91.90	--- Барилгын бусад угсармал хийц, хэсэглэл		20%
69	69.04	6904.10.00	- Барилгын тоосго	5%	20%
94	94.03	9403.30.00	- Албан газрын зориулалттай модон тавилга	5%	20%
		9403.40.00	- Гал тогооны өрөөний зориулалттай модон тавилга	5%	20%
		9403.50.00	- Унтлагын өрөөний зориулалттай модон тавилга	5%	20%
		9403.60.00	- Бусад модон тавилга	5%	20%

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 193

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6.1.3, 6.1.4, 11.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг 1 дүгээр, “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд олгогдох дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавих журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.



2. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас дэмжлэг олгоход шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Болор, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД

Д.ЭРДЭНЭБАТ

Засгийн газрын 2016 оны 193 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН
ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ,
ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан (цаашид “сан” гэх)-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Сан нь Төрийн санд тусгай данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг гагцхүү тус дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

1.3. Сан энэ журмын 1.2-т заасан сангаас гадуур данстай байхыг хориглоно.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сангийн үйл ажиллагааг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах бөгөөд тус байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. сангийн тухайн жилийн төсвийг боловсруулж батлуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах;

2.1.2. энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу сангийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн мэдээлэл, бичиг баримтын иж бүрдлийг нягтлан шалгаж, холбогдох дүгнэлтийн хамт мөн журмын 2.2-т заасан хороонд шилжүүлэх;



2.1.3. энэ журмын 2.6-д заасан шийдвэрийг үндэслэн төрөөс үйлдвэрлэлийг дэмжих дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, санхүүжилт олгох;

2.1.4. сангийн үйл ажиллагаатай холбогдох бичиг баримтыг хадгаламжийн нэгж болгон архивт шилжүүлэх;

2.1.5. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

2.2. Сангийн хөрөнгөөс дэмжлэг олгох аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах үүрэг бүхий хороо (цаашид “Хороо” гэх) ажиллана. Хороог үйлдвэрлэлийн салбарын төлөөллийг оролцуулан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

2.3. Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг хорооны гишүүдийн олонхийн саналаар зарлан хуралдуулж болно. Хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.4. Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна. Хорооны шийдвэрт дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.5. Хороо нь “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд олгогдох дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавих журам”-ын 2, 3 дугаар зүйлд заасан дэмжлэгт хамрагдах шалгуур үзүүлэлт хангасан аж ахуйн нэгжийн талаарх шийдвэрийг гарснаас нь хойш ажлын 3 хоногийн дотор аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

2.6. Аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 2.5-д заасан шийдвэртэй танилцаж, дэмжлэг олгох аж ахуйн нэгжийн талаар эцсийн шийдвэр гаргаж, дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгжийн нэрс, санхүүжилтийн хэмжээг баталгаажуулна. Дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгж нь Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Гурав. Сангийн хөрөнгийн эх үүсвэр болон
түүнийг зарцуулах журам

3.1. Сангийн хөрөнгө Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

3.1.1. улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

3.1.2. сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

3.1.3. олон улсын байгууллага, гадаад улсаас үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон зээл;

3.1.4. олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж;

3.1.5. бусад эх үүсвэр.

3.2. Сангийн хөрөнгийг Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1-д заасны дагуу дараах зориулалтаар зарцуулна:

3.2.1. үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох;

3.2.2. өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг 1 удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгох;

3.2.3. экспортын үйлдвэрлэлийг экспортын санхүүжилтийн төрөл бүрийн арга хэрэгсэл, түүний дотор факторингийн үйлчилгээг хөгжүүлэх замаар дэмжих.

3.3. Гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрт тусгайлан заасан тохиолдолд зээл, хандив, буцалтгүй тусламжийг зөвхөн тухайн гэрээ, хэлэлцээрт заасан зориулалтын дагуу зарцуулна.



3.4. Сангийн хөрөнгөөс зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд дэмжлэг олгоно.

3.5. Сангийн хөрөнгийг энэ журмын 3.2-т зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Сангийн төсөв

4.1. Сангийн жил бүрийн орлого, зарлагын төсвийг Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу баталж хуваарилна.

4.2. Аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жил үйлдвэрлэлийн дэмжлэг олгоход шаардагдах хөрөнгийн талаар санал боловсруулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн төсвийн төсөлтэй хамт хүргүүлнэ.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан

5.1. Аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сангийн орлого, зарлагын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана. Аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сангийн хөрөнгөөс дэмжлэг олгосон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт тайлагнана.

5.2. Сангийн хөрөнгийн зарцуулалтад Төсвийн тухай хуульд заасны дагуу хяналт тавина.

Зургаа. Бусад зүйл

6.1. Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан буюу шалгуур үзүүлэлт хангаагүй аж ахуйн нэгжид дэмжлэг олгосон бөгөөд хууль тогтоомж, энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ ХҮСЭЛТ
ГАРГАСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Мэдээлэл	Тайлбар												
1.1	Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн нэр	Хуулийн этгээдийн нэр												
1.2	Регистрийн дугаар	Регистрийн дугаар												
1.3	Улсын бүртгэлийн дугаар	Татварын байгууллагад бүртгэгдсэн улсын бүртгэлийн дугаар												
1.4	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагаа явуулж байгаа салбарын нэр: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын кодыг бичнэ. (Сангийн сайдын 2011.01.29-ний өрдийн 103 тоот тушаалын хавсралтыг ашиглана)												
1.5	Үйл ажиллагааны төрөл	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Үйл ажиллагааны үндсэн чиглэл</th> <th>Үйл ажиллагааны туслах чиглэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Үйл ажиллагааны туслах чиглэл	1			2			3		
№	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Үйл ажиллагааны туслах чиглэл												
1														
2														
3														
1.6	Байгууллагын хаяг	Албан ёсоор бүртгүүлсэн хаяг												
1.7	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа байрны талаарх мэдээлэл	<p>Аймаг, нийслэл Сум, дүүрэг Баг, хороо Гудамж, хороолол Газарзүйн солбицол Байшин, байр Хашаа, хаалганы дугаар Утас Факс Цахим шуудан Цахим хуудас Өөрийн байр эсвэл түрээсийн байр эсэх (1-ээс олон байршилд эсвэл нэгээс олон төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа бол салбар, төлөөлөгчийн газрын байршил тус бүрээр, эсхүл үйл ажиллагааны төрөл тус бүрээр бичнэ)</p>												
1.8	Байгуулагдсан он	Тухайн байгууллагын байгуулагдсан он Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг эсэх												

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



		Овог, нэр Албан тушаал Утас Цахим шуудан																																				
1.9	Аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтны талаарх мэдээлэл	Хувыцаат компани Хягаарлагдмал хариуцлагатай компани Бусад: (дэлгэрэнгүй бичих)																																				
1.10	Хариуцлагын хэлбэр	Төрийн өмчийн Төрийн өмчийн оролцоотой ... % Орон нутгийн өмчийн Орон нутгийн өмчийн оролцоотой ... % Хувийн (Монгол Улсын)																																				
2.1	Өмчийн хэлбэр																																					
		<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Үзүүлэлт</th> <th>Ашиглагтад орсон огноо</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Тоо, хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нийт хөрөнгө Үүнээс:</td> <td>Үндсэн</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Нийт үл хөдлөх хөрөнгө</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Газар</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td>Барилга</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дамжуулах байгууламж</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td>Тоног төхөөрөмж</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>		№	Үзүүлэлт	Ашиглагтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	1	Нийт хөрөнгө Үүнээс:	Үндсэн				Нийт үл хөдлөх хөрөнгө					Газар				2	Барилга					Дамжуулах байгууламж				3	Тоног төхөөрөмж			
№	Үзүүлэлт	Ашиглагтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ																																		
1	Нийт хөрөнгө Үүнээс:	Үндсэн																																				
	Нийт үл хөдлөх хөрөнгө																																					
	Газар																																					
2	Барилга																																					
	Дамжуулах байгууламж																																					
3	Тоног төхөөрөмж																																					
2.2	Үндсэн хөрөнгийн хэмжээ																																					
		<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Үзүүлэлт</th> <th>Сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нийт эргэлтийн хөрөнгө</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Үүнээс:</td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td>Мөнгөн хөрөнгө</td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td>Авлага</td> <td></td> </tr> </tbody> </table>		№	Үзүүлэлт	Сая төгрөг	1	Нийт эргэлтийн хөрөнгө			Үүнээс:		2	Мөнгөн хөрөнгө		3	Авлага																					
№	Үзүүлэлт	Сая төгрөг																																				
1	Нийт эргэлтийн хөрөнгө																																					
	Үүнээс:																																					
2	Мөнгөн хөрөнгө																																					
3	Авлага																																					
2.3	Эргэлтийн хөрөнгийн хэмжээ																																					
2.4	Өр төлбөрийн хэмжээ	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Үзүүлэлт</th> <th>Сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Дансны өглөг</td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td>Богино хугацааны банкны зээл</td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td>Урт хугацааны банкны зээл</td> <td></td> </tr> </tbody> </table>		№	Үзүүлэлт	Сая төгрөг	1	Дансны өглөг		2	Богино хугацааны банкны зээл		3	Урт хугацааны банкны зээл																								
№	Үзүүлэлт	Сая төгрөг																																				
1	Дансны өглөг																																					
2	Богино хугацааны банкны зээл																																					
3	Урт хугацааны банкны зээл																																					
2.5	Борлуулалтын орлого (сая төгрөг)	Тухайн тайлант жилийн борлуулалтын орлогын хэмжээ (ЭЗҮАСА-ын кодоор)																																				

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

	2.6 Үйл ажиллагааны зардал	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="146 847 165 879">№</th> <th data-bbox="165 443 199 879">Үзүүлэлт</th> <th data-bbox="199 193 247 879">Зардлын хэмжээ, сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="191 847 210 879">1</td> <td data-bbox="191 564 210 879">Үйл ажиллагааны нийт зардал</td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="210 847 229 879">2</td> <td data-bbox="210 564 229 879">Цалин хөлсний зардал</td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="229 847 248 879">3</td> <td data-bbox="229 564 248 879">Нийгмийн даатгалын шимтгэл Тээврийн зардал</td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="248 847 267 879">4</td> <td data-bbox="248 651 267 879">Авто тээвэр Төмөр замын тээвэр Агаарын тээвэр Усан замын тээвэр</td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Үзүүлэлт	Зардлын хэмжээ, сая төгрөг	1	Үйл ажиллагааны нийт зардал		2	Цалин хөлсний зардал		3	Нийгмийн даатгалын шимтгэл Тээврийн зардал		4	Авто тээвэр Төмөр замын тээвэр Агаарын тээвэр Усан замын тээвэр										
№	Үзүүлэлт	Зардлын хэмжээ, сая төгрөг																								
1	Үйл ажиллагааны нийт зардал																									
2	Цалин хөлсний зардал																									
3	Нийгмийн даатгалын шимтгэл Тээврийн зардал																									
4	Авто тээвэр Төмөр замын тээвэр Агаарын тээвэр Усан замын тээвэр																									
	2.7 Судалгаа хөгжүүлэлтийн зардал	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="388 847 407 879">№</th> <th data-bbox="388 443 422 879">Үзүүлэлт</th> <th data-bbox="422 193 470 879">Татварын хэмжээ, сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="380 847 399 879">1</td> <td data-bbox="380 596 399 879">Үйлдвэрлэлийг хөгжүүлэх</td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="399 847 418 879">2</td> <td data-bbox="399 596 418 879">Бүтээгдэхүүнээ хөгжүүлэх</td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="418 847 437 879">3</td> <td data-bbox="418 564 437 879">Нийгмийн даатгалын шимтгэл</td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="437 847 456 879">4</td> <td data-bbox="437 660 456 879">Зөвлөх үйлчилгээ</td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Үзүүлэлт	Татварын хэмжээ, сая төгрөг	1	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх		2	Бүтээгдэхүүнээ хөгжүүлэх		3	Нийгмийн даатгалын шимтгэл		4	Зөвлөх үйлчилгээ										
№	Үзүүлэлт	Татварын хэмжээ, сая төгрөг																								
1	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх																									
2	Бүтээгдэхүүнээ хөгжүүлэх																									
3	Нийгмийн даатгалын шимтгэл																									
4	Зөвлөх үйлчилгээ																									
	2.8 Охин болон толгой компанийн талаарх мэдээлэл	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="539 847 558 879">№</th> <th data-bbox="539 715 573 879">Ямар компани (толгой/ охин)</th> <th data-bbox="539 564 573 715">Компанийн нэр</th> <th data-bbox="539 480 573 564">Регистрийн дугаар</th> <th data-bbox="539 331 573 480">Үйл ажиллагааны үндсэн чиглэл</th> <th data-bbox="539 193 573 331">Үйл ажиллагааны туслах чиглэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="532 847 551 879">1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="551 847 570 879">2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="570 847 589 879">3</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Ямар компани (толгой/ охин)	Компанийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Үйл ажиллагааны туслах чиглэл	1						2						3					
№	Ямар компани (толгой/ охин)	Компанийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Үйл ажиллагааны туслах чиглэл																					
1																										
2																										
3																										
ӨНӨГТНИЙ БАЙДАЛ	3.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үнэ	<p>Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээ, тухайн бүтээгдэхүүний зах зээлд борлуулагдаж байгаа үнэ ханш (ЭЗУАСА 4.0-оор), бүтээгдэхүүний код</p> <table border="1"> <thead> <tr> <th data-bbox="738 847 757 879">№</th> <th data-bbox="738 699 771 879">Бүтээгдэхүүн</th> <th data-bbox="738 564 771 699">Хэмжих нэгж</th> <th data-bbox="738 331 771 564">Тоо хэмжээ</th> <th data-bbox="738 193 771 331">Үнэ, сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="730 847 749 879">1</td> <td data-bbox="730 699 763 879">Зураасан код, барааны тэмдэг</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="749 847 768 879">2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг	1	Зураасан код, барааны тэмдэг				2													
№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг																						
1	Зураасан код, барааны тэмдэг																									
2																										
	3.2 Агуулахын багтаамж, хүчин чадал	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="885 847 904 879">№</th> <th data-bbox="885 683 919 879">Агуулахын нэр</th> <th data-bbox="885 564 919 683">Байршил</th> <th data-bbox="885 432 919 564">Зориулалт</th> <th data-bbox="885 331 919 432">Багтаамж</th> <th data-bbox="885 193 919 331">Төрөл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="878 847 897 879">1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td data-bbox="897 847 916 879">2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Агуулахын нэр	Байршил	Зориулалт	Багтаамж	Төрөл	1						2											
№	Агуулахын нэр	Байршил	Зориулалт	Багтаамж	Төрөл																					
1																										
2																										



	<p>Бүтээгдэхүүн тээврийн хэрэгсэл</p> <p>Борлуулахад ашигласан</p>	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Тоо хэмжээ</th> <th>Үнэ, сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг	1					2																		
№	Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг																											
1																															
2																															
<p>3.4 Зорилтот зах зээл</p>	<p>Дотоодын зах зээл</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Тоо хэмжээ</th> <th>Үнэ, сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> <p>Гадаадын зах зээл</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг</th> <th>Хэмжих нэгж</th> <th>Тоо хэмжээ</th> <th>Үнэ, сая төгрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг	1					2					№	Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг	1					2				
№	Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг																											
1																															
2																															
№	Бүтээгдэхүүн зураасан код, барааны тэмдэг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ, сая төгрөг																											
1																															
2																															
<p>3.5</p>	<p>Техник, технологийн шийдэл</p>	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Нэвтрүүлсэн техник, технологийн нэр</th> <th>Техник технологийн үзүүлэлт</th> <th>Улс</th> <th>Нэвтрүүлсэн он, сар, өдөр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Нэвтрүүлсэн техник, технологийн нэр	Техник технологийн үзүүлэлт	Улс	Нэвтрүүлсэн он, сар, өдөр	1					2					3													
№	Нэвтрүүлсэн техник, технологийн нэр	Техник технологийн үзүүлэлт	Улс	Нэвтрүүлсэн он, сар, өдөр																											
1																															
2																															
3																															

Дотоодоос авсан түүхий эд

№	Түүхий эдийн нэр	Хаанаас (нийлүүлэгчийн нэр)	Нийлүүлэгчийн хааг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ
1			Аймаг, нийслэл Сум, дүүрэг Баг, хороо Гудамж, Байшин, байр Хашаа, хаалганы дугаар			

Гадаадаас авсан түүхий эд

№	Түүхий эдийн нэр	Хаанаас (нийлүүлэгчийн нэр)	Нийлүүлэгчийн хааг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ
1			Аймаг, нийслэл Сум, дүүрэг Баг, хороо Гудамж, Байшин, байр Хашаа, хаалганы дугаар			

Монгол Улсын үндэсний ажил, мэргэжлийн ангилал болон тодорхойлолт
УАМАТ-08 код (ISCO-08)-ын дагуу

№	УАМАТ-08 (ISCO-08) код	Нийт ажилчдын тоо	Эрэгтэй	Эмэгтэй	30 хүртэлх насны ажилчдын тоо	50-иас дээш насны ажилчдын тоо	Боловсролын түвшин
1							
2							
3							

3.6 Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчийн талаарх мэдээлэл

3.7 Ажиллах хүчний мэдээлэл



ИРЭЭДҮЙН ТАМАГЛАЛ		Үйлдвэрлэхээр зорьж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээгдэхүүний код, 1-ээс олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бол бүтээгдэхүүн тус бүрээр				
		№ Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (2016-2020 он)	Үнэ, сая төгрөг (2016-2020 он)	
4.1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зорилт (5 жил, 10 жилийн дараах үр дүн)	1				
		2				
		3				
Агуулахын байршил, багтаамж, хүчин чадал						
4.2	Агуулахын багтаамж, хүчин чадал (5 жил, 10 жилийн дараах үр дүн)	№ Агуулах	Байршил	Зориулалт	Төрөл	Багтаамж (2016-2020 он)
		1				
		2				
4.3	Бүтээгдэхүүн борлуулахад ашиглах тээврийн хэрэгсэл (5 жил, 10 жилийн дараах үр дүн)	№ Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (2016-2020 он)		Тээврийн хэрэгсэл
		1				
		2				
Дотоодын зах зээл						
4.4	Ирээдүйд үйлдвэрлэлийн хэмжээ өсөн нэмэгдэхэд өргөжих зорилтот зах зээл (5 жил, 10 жилийн дараах үр дүн)	№ Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (2016-2020 он)	Үнэ, сая төгрөг (2016-2020 он)	Нийлүүлэх зах зээл
		1				
		2				
		3				
Гадаадын зах зээл						
		№ Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (2016-2020 он)	Үнэ, сая төгрөг (2016-2020 он)	Аль улсад нийлүүлэх
		1				
		2				
		3				

№	Нэвтрүүлсэн техник, технологийн нэр	Техник технологийн үзүүлэлт	Улс	Нэвтрүүлсэн он, сар, өдөр
1				
2				
3				

Дотоодоос авсан түүхий эд

Түүхий № эдийн нэр	Хаанаас (нийлүүлэгчийн нэр)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (2016-2020 он)	Үнэ (2016-2020 он)
1				
2				

Гадаадаас авах түүхий эд

Түүхий № эдийн нэр	Хаанаас (нийлүүлэгчийн нэр)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (2016-2020 он)	Үнэ (2016-2020 он)
1				
2				

№	ISCO-08 код (YAMAT-06) код	Нийт ажилчдын тоо		Эмэгтэй		30 хүртэлх насны ажилчдын тоо		50-нас дахь насны ажилчдын тоо	
		2020	2025	2020	2025	2020	2025	2020	2025
1									
2									

Тайлбар: мэдээллийг www.industry.mn сайт руу орж үйлдвэрийн салбарын мэдээллийн санд давхар бүртгүүлсэн байна.



Засгийн газрын 2016 оны 193 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД ОЛГОГДОХ
ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ, ТООЦОХ, ДЭМЖЛЭГИЙГ
ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд олгогдох дэмжлэг (цаашид “дэмжлэг” гэх)-т хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн чиглэл нь Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” болон Засгийн газрын 2015 оны 396 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-тэй уялдсан байна.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “эргэлтийн хөрөнгө” гэж төслийн хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор ашиглагдаж байгаа мөнгөн хөрөнгөд хөрвүүлэх боломжтой хөрөнгийг;

1.3.2. “экспортын санхүүжилтийн арга хэрэгсэл” гэж аж ахуйн нэгжийн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор бизнесийн үйл ажиллагааны өртөг, зардлыг бууруулж, эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн болон экспортын даатгалд хамруулах, гадаад худалдааны төлбөр тооцооны арга хэрэгслүүдийн нийлбэрийг.

Хоёр. Дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн
шалгуур үзүүлэлтийг тогтоох

2.1. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.1-8.1.3-т заасан дэмжлэгт хамрагдах шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтооно:

2.1.1. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.1-д заасан дэмжлэгийн шалгуур үзүүлэлт: үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргадаг байх;

2.1.2. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.2-т заасан дэмжлэгийн шалгуур үзүүлэлт: дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан аж

ахуйн нэгж нь технологийн түвшний нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байх;

2.1.3. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.3-т заасан дэмжлэгийн шалгуур үзүүлэлт: экспортын үйлдвэрлэл эрхэлдэг байх.

2.2. Энэ журмын 2.1.1-2.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.1-8.1.3-т заасан дэмжлэгт хамруулахгүй.

2.3. Дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгж нь Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 9.3-т заасан үнэлгээг хийлгэсэн байна.

Гурав. Дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн
шалгуур үзүүлэлтийг тооцох

3.1. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.1-д заасан дэмжлэгт хамрагдах тохиолдолд:

3.1.1. аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар болон аж ахуйн нэгжийн ирүүлсэн санхүүгийн болон холбогдох бусад баримттай тулган баталгаажуулсны үндсэн дээр тогтооно;

3.1.2. аж ахуйн нэгжийн экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний хэмжээг Гааль, татварын ерөнхий газрын статистик мэдээллийг үндэслэн тогтооно;

3.1.3. дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгж $X/Y \cdot 100\% > 30\%$ нөхцөлийг хангасан байна¹.

3.2. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.2-т заасан дэмжлэгт хамрагдах тохиолдолд:

3.2.1. технологийн түвшний үнэлгээ хийх эрх бүхий байгууллага тухайн аж ахуйн нэгжийн технологийн түвшинд холбогдох хууль тогтоомжийн дагуу нарийвчилсан үнэлгээ хийж, уг технологийг бий болгох, нэвтрүүлэх, нутагшуулахад гаргасан судалгаа, хөгжлийн зардал, технологийн түвшний шинэчлэл хийсэн эсэх талаар дүгнэлт хийж, тайлан гаргана;

3.2.2. дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгж нь технологийн түвшний нарийвчилсан үнэлгээний тайланг дүгнэлтийн хамт аж үйлдвэрийн

¹ X-тухайн аж ахуйн нэгжийн экспортын хэмжээ, Y-тухайн аж ахуйн нэгжийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ



асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Тухайн нэгж уг баримтуудыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагаар аудит, хяналт-шинжилгээ, магадлагаа хийлгэж болно.

3.3. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.3-т заасан дэмжлэгт хамрагдах тохиолдолд:

3.3.1. экспортын санхүүжилтийн арга хэрэгслүүд, түүний дотор факторингийн үйлчилгээгээр бүтээгдэхүүнээ экспортод гаргасан тохиолдолд банкны баталгаа, гэрээний гүйцэтгэл, төлбөр төлсөн баримт, бараа, бүтээгдэхүүн ачуулсан тухай гаалийн болон холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн баримтыг үндэслэнэ;

3.3.2. экспортод гаргасан бараа, бүтээгдэхүүний төлбөрөөс үүссэн авлагыг факторингийн үйлчилгээгээр барагдуулах тохиолдолд гэрээгээр тохирсон хугацаанд тухайн авлагыг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн үнийн дүнгээр тогтооно.

Дөрөв. Дэмжлэг олгох

4.1. Дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгжид олгох дэмжлэгийг “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу олгоно.

Тав. Бусад зүйл

5.1. Энэ журмын хэрэгжилтэд аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хяналт тавьж ажиллана.

5.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 14003